

## **ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 5-д “Монгол Улсын иргэн нь “хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй””, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангах”, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй...” гэж тус тус заасан.

Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйлд “энэ хуулийн үйлчлэлд дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь нэг нас хүрсэн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцлийг хангасан эх” хамаарна гэж заасан бөгөөд мөн хуулийн 3.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан “дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй” гэж заасан.

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонг, дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонг олгож байна. Ингэхдээ хамгийн бага хүүхэд нь 1 нас хүрэхэд дөрөв болон зургаагаас дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд үрчлэн авсан хүүхдийг хамруулан олгож байна.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн зохицуулалтаар урамшуулал авах болзолд “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд нь 1 ба түүнээс дээш настай байсан байх” зэрэг нөхцөл тавигдаж байгаа нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийг зөрчиж, хүүхдийг насаар нь ялгаварлах гадуурхах нөхцөл бүрдүүлснийг засах, хүний эрхэм чанарыг хүндэтгэх төрийн үүргийг хангах шаардлагатай байгаа тул “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулав.

Энэхүү хуулийн төсөлд олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд урамшуулал олгох шалгуурыг багасгах буюу хөнгөлөхөөр тусгасан. Тодруулбал, урамшуулал авахад тавигддаг “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд 1 ба түүнээс дээш настай байх” зэрэг шаардлагуудыг хасахаар тусгалаа.

Хуулийн төслийн зорилго нь 1 нас хүрээгүй хүүхдээ алдсан эхчүүдийн эрхийг хамгаалах, энэхүү урамшуулал, дэмжлэгийн тогтолцоонд хамруулах, олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийг ялгаварлахгүй байх, төрөлтийг дэмжих, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хуулийн төсөлд

Хуулийн төсөл 2 зүйлтэй бөгөөд төсөлд дараах асуудлыг тусгав. Үүнд:

1. Төслийн 1 дүгээр зүйлд хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэгт дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, нас барсан хүүхдийг хамруулахаар тусгав.

2. Төслийн 2 дугаар зүйлд хууль хэрэгжиж эхлэх хугацааг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс байхаар тусгав.

Энэхүү төсөл батлагдсанаар “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одон авах эхчүүдийн тоо 10,154 хүнээр, 2 дугаар зэргийн одон авах эхчүүдийн тоо 27,140 хүнээр нэмэгдэж, 7.5 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэрийг улсын төсөвт тусгах шаардлагатай болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын дагуу Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйл, заалтад тандан судалгаа хийв.

---o0o---